



ЗАМ, ТЭЭВРИЙН  
ХӨГЖЛИЙН ЯАМ



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ  
ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

## ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРТ ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧИГ

Нийслэлийн иргэдийн амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх, нийслэлийн тээврийн сүлжээг өргөжүүлэн хөгжүүлэх, эрэлтэд нийцсэн тээврийн үйлчилгээг үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор нэг талаас Зам, тээврийн хөгжлийн сайд /цаашид –“сайд” гэх/, нөгөө талаас Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч /цаашид “Засаг дарга” гэх/ нар 2018-2020 онд хамтран ажиллахаар энэхүү “Санамж бичиг”-ийг байгуулав.

### Нэг. Ерөнхий зүйл

1.1. Талууд дараах бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллана. Үүнд:

- 1.1.1. “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”;
- 1.1.2. “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”;
- 1.1.3. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр;
- 1.1.4. “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний стратеги”;
- 1.1.5. “Осол гэмтэл, хүчирхийллээс сэргийлэх үндэсний хөтөлбөр”;
- 1.1.6. “Эрүүл хот, дүүрэг, сум, баг, ажлын байр, сургууль бий болгох үндэсний хөтөлбөр”;
- 1.1.7. Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөө;
- 1.1.8. Авто замын мастер төлөвлөгөө;
- 1.1.9. Зам, тээврийн салбарт болон нийслэлд хэрэгжүүлэх бодлогын баримт бичиг, төсөл хөтөлбөрүүд;

1.2. Талууд хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг зохион байгуулна.

1.3. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас жил тутамд хэлэлцэж дүгнэх ба Талууд төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, хяналт тавих, нэгдсэн удирдамжаар хангах үүрэг бүхий байнгын хамтарсан Ажлын хэсэг байгуулж ажиллана.

1.4. Талууд харилцан тохиролцсоны дагуу энэхүү “Санамж бичиг”-т нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

### Хоёр. Хамтын ажиллагааны чиглэл

Талууд дараах чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцов. Үүнд:

2.1. Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, Улаанбаатар хотын 2030 он хүртэлх мастер төлөвлөгөөтэй уялдуулан автозамын сүлжээг өргөтгөн хөгжүүлэх, авто зогсоолуудын тоо, хүчин чадлыг нэмэгдүүлэх;

2.2. Улаанбаатар хотын авто замын сангийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, авто зам, автотээврийн хэрэгслийн ашиглалтын байдалд тавих хяналт, эрх зүйн зохицуулалтыг сайжруулах;

2.3. Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, төмөр зам дагуух төвлөрлийг сааруулах, гарц гармыг нэмэгдүүлэх талаар чиглэгдсэн арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх, тээврийн хэрэгслийн ашиглалтын эсрэг гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх;

2.4. Улаанбаатар хотод ачаа тээврийн нэгдсэн логистикийн төвүүдийг байгуулах, хүрээлэн буй орчинд ээлтэй тээврийн ухаалаг систем, аялал жуулчлалын шинэ чиглэл, тээврийн шинэ үйлчилгээ нэвтрүүлэх;

2.5. Автотээвэр /нийтийн тээвэр, хүүхдийн автобус/, иргэний агаарын тээвэр, төмөр замын тээврийн үйлчилгээний нэгдсэн сүлжээг бий болгох замаар нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх;

2.6. Тээврийн хэрэгслийн ашиглалтын улмаас хүрээлэн буй орчинд үзүүлж буй сөрөг үр дагаврыг бууруулах, зам, тээврийн салбарын үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх, зам, тээврийн салбарт үүсэж буй хог хаягдлыг дахин боловсруулах, устгах зохистой тогтолцоог бий болгох;

### Гурав. Бусад зүйл

3.1. Санамж бичиг нь Талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД

Ж.БАТ-ЭРДЭНЭ

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД  
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ

С.БАТБОЛД